



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 29

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих арга хэмжээний санал боловсруулах, “Нээлттэй Өвөрхангай” хөтөлбөрийн уулзалт хэлэлцүүлгийн арга хэмжээний зардалд 6,853,000 (зургаан сая найман зуун тавин гурван мянга) төгрөгийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 6,853,000 (зургаан сая найман зуун тавин гурван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0059

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны
01 дүгээр сарын 11-ны өдрийн
11.29 дугаар захирамжийн
хавсралт



УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТӨСӨВ

№	Зарцуулалт	Тоо хэмжээ	Нэгж	Нэг бүрийн үнэ (төг)	Нийт үнэ (төг)
1	Уулзалт, хэлэлцүүлэгт оролцогчдын үдийн хоол	180	ш	28,800	5,184,000
2	Баннер	8.8	м.кв	23863,6	210,000
3	Эх бэлтгэл, тайзны биет лого, рам, гэрэлтүүлэг, сурталчилгаа			590,000	590,000
4	Стэнд хийлгэх	3	ш	100,000	300,000
5	Завсарлага (ус)	180	ш	1,500	270,000
6	Бусад			299,000	299,000
Нийт					6,853,000

-оОо-